


МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 4/369.

Мандалговь

Г Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", "ж", Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 171 дүгээр тогтоол, аймгийн Онцгой комиссын 2020 оны 27 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Коронавируст (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 06.00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 06.00 цаг хүртэл сунгасугай.

Хоёр. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг баар, цэнгээний газар, караоке, бария массаж, фитнес, саун, цахим тоглоом, сүм хийдийн хурал, хичээл сургалт, семинар, цугларалт, хэлэлцүүлэг, курс дамжаа, секц, дугуйлан, үзвэр, спорт заал, уралдаан тэмцээн болон олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах, Архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 06.00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 06.00 цаг хүртэл хугацаанд хориглосугай.

Гурав. Хөл хорио тогтоосон хууль тогтоомжийг мөрдэж, онцын шаардлагагүй бол гэрээсээ гарагчийг байж, мэргэжлийн байгууллагуудын зөвлөмжийг хэрэгжүүлэн, халдварт, хамгааллын дэглэмийг баримтлахыг аймгийн нийт иргэдэд уриалсугай.

Дөрөв. Аймаг, сумд хоорондын зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг аймгийн Онцгой комиссын зөвшөөрлөөр хязгаарлаж, дамжин өнгөрч буй тээврийн хэрэгслийг зогсоохгүй өнгөрүүлэхээр зохицуулсугай.

Тав. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгасантай холбогдуулан 15 суманд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээр нэvtэрч байгаа автомашин, иргэдэд тавих хяналт, шалгалтыг эрчимжүүлж, голомтын бүс нутгаас нэvtэрч байгаа иргэдийн PCR шинжилгээг сайтар нягтлан 48 цаг өнгөрсөн, шинжилгээний хариу www.119.mn цахим сайтад хүлээлгийн горимд байгаа гэсэн өгүүлэмжтэй иргэдийг нэвтрүүлэхгүй байхыг сумдын Засаг дарга наарт үүрэг болгосугай.

Зургаа. Голомтын бүс нутгаас ирж гэрийн ажиглалтад байгаа иргэд, ар гэрийнхэнд тавих хяналтыг сайжруулж, мэдээ, мэдээлэл, заавар зөвлөмжөөр хангаж ажиллахыг сумдын Засаг дарга, Эрүүл мэндийн төвийн дарга наарт үүрэг болгосугай.

Долоо. Төрийн байгууллагуудыг ажлын тусгай горимоор ажиллуулах цагийн хуваарийг баталж мөрдүүлэн ажиллахыг сумдын Засаг дарга, байгууллагын дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.

Найм. Захирамжийг хэрэгжүүлж, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар тухай бүр нь танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Ч.МОНХБАТ

482011076